

Шууд санхүүжилтын хэлэлцээр MCM 2

| | |
|---------------------------------|----------------------------|
| Улс: | Монгол Улс |
| Төслийн дугаар: | 56048 |
| Бизнесийн салбар: | Үйлдвэрлэл үйлчилгээ |
| Мэдэгдлийн төрөл: | Хувийн хэвшил |
| Байгаль орчны ангилал: | В |
| Хэлэлцэх хурлын огноо: | 2025 оны 4 дүгээр сарын 15 |
| Төлөв байдал: | Батлагдсан |
| Төслийн хураангуйг танилцуулсан | 2025 оны 4 дүгээр сарын 25 |

Төслийн танилцуулга

MCM Групп ("Компани" эсвэл "Харилцагч")-д 26.25 тэрбум төгрөгийн (ойролцоогоор 6.96 сая евро) анхдагч өглөгт тооцогдох барьцаагүй зээл. Тус зээлээр харилцагчийн Монгол улсын өмнөд хэсэгт агуулахын байгууламж, ложистикийн төв, засвар үйлчилгээ, авто машины шоурүүм барих болон эргэлтийн хөрөнгийн хэрэгцээг санхүүжүүлнэ. Компани тус төслийг хэрэгжүүлсэнээр компанид хэрэглэгчдэдээ илүү хурдан хүргэлт хийх боломжийг олгож, үйл ажиллагааны үр ашигтай байдлыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

Шилжилтийн нөлөөлөл

Хүлээгдэж буй шилжилтийн нөлөөлөл (ХШН)-ийн оноо:66

Шилжилтийн нөлөөлөл нь өрсөлдөх чадвар болон ногоон чанаруудад оруулах хувь нэмрээс үүдэлтэй байх төлөвтэй байна.

"Өрсөлдөх чадвар": MCM компаний бараа материалын менежмент, түгээлтийн процессыг шинэ агуулах байгууламж болон ложистикийн төв нь илүү оновчтой болгож, хүргэлтийн хугацааг одоогийн 2,4 хоногийг ердөө 1 өдөр болгон богиносгоно. Энэхүү сайжруулалт нь тээвэрлэхэд аюулгүй ажиллагааны дүрэм журмыг мөрдөх шаардлагатай химийн бүтээгдэхүүн тээвэрлэхэд онцгой ач холбогдолтой.

"Ногоон": Зээлийн санхүүжилтээр баригдах бүтээн байгуулалт нь EPC В барилгын гэрчилгээ авснаар эрчим хүч хэрэглээг хамгийн багадаа 20% хэмнэх болно.

Харилцагчийн мэдээлэл

МСМ Групп ХХК

1998 онд байгуулагдсан МСМ Групп (“Компани”, “МСМ” эсвэл “Зээлдэгч”) нь үндсэн гурван салбарт үйл ажиллагаа явуулдаг: (i) автомашин (ii) аж үйлдвэрлэл (iii) шингэн хүнс. Зах зээлдээ тэргүүлэгч эсвэл салбартаа гол тоглогч гэдгээрээ компани хүлээн зөвшөөрөгдсөн. МСМ Групп нь 2008 оноос хойш ЕСБХБ-ны харилцагч болсон.

ЕСБХБ-ны санхүүжилтийн тойм

26,250,000,000.00 төгрөг

26.25 тэрбум (6.96 сая евро) анхдагч өглөгт тооцогдох барьцаагүй зээл хоёр транчаар

Төслийн нийт өртөг

26,250,000,000.00 төгрөг

Төслийн нийт өртөг 26.25 тэрбум.

Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны хураангуй

В ангилал (2024 оны БОНБ). Тус төсөлтэй холбоотой байгаль, нийгмийн хүрээний асуудлууд нь багавтар байна. Компани нь Банкны харилцагч бөгөөд байгаль орчин, нийгмийн асуудлууд дээр авч хэрэгжүүлж буй гүйцэтгэл нь банкны шаардлагыг хангасаар байна. Компани нь байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны Монгол Улсын холбогдох шаардлагуудад нийцүүлж ажиллаж байгаа ба байгаль орчны ISO 14001 болон эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны ISO 45001 зэрэг удирдлагын цогц гэрчилгээжүүлсэн хөтөлбөрүүдийг хангаж ажиллаж байна. Үүнтэй холбоотой холбогдох бодлого журам нь компанийн цахим хуудсанд нээлттэй байна. Банкнаас тавьж буй байгаль орчин нийгмийн, жишээлбэл хүний нөөцийн удирдлага, шаардлагуудыг хангахад шаардлагатай асуудлуудыг удирдан зохион байгуулахад тохирох ажилтнуудыг компани нь ажиллуулж байна. Иймээс банкнаас тавьж буй одоогийн байгаль орчин, нийгмийн нийцлийн шаардлагуудыг хангаж ажиллах үүднээс одоогоор компаниас тайлагнаж байгаа байгаль орчин нийгмийн жилийн тайлагналаас гадна нэмэлтээр арга хэмжээ авах шаардлага байхгүй байна.

Техникийн хамтын ажиллагаа

Байхгүй

Нэмэлт ашиг тус

Санхүүжилтийн бүтэц: ЕСБХБ нь зах зээл дээр байгаа арилжааны нөхцөлтэй зээлүүдээс илүү боломжийн нөхцөлөөр санхүүжилтийг санал болгодог. Жишээлбэл илүү урт хугацаагаар. Ийм санхүүжилт төслийг хэрэгжүүлэхэд компанид зайлшгүй шаардлагатай байдаг.

Эрсдэл бууруулах: ЕСБХБ-ны үйлчлүүлэгчтэй тогтоосон урт хугацааны харилцаа нь үйлчлүүлэгчээс инноваци, шинэ зах зээлд нэтрэх боломжийг олгох илүү их эрсдэл болон санхүүжилт шаардах төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Холбоо барих хүний мэдээлэл

Марк Габел

information@msmco.net

+976 7718 1111

<https://www.msmgroup.mn/>

МСМ Групп ХХК, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө 62, Үйлдвэрлэлийн бүс, Улаанбаатар хот 17070

Төслийн хураангуйг шинэчилсэн:

2025 оны 4 дүгээр сарын 25

Шилжилтийг ойлгох нь

Шилжилтийн нөлөөллийг хэмжих чиглэлд ЕСБХБ-ны баримталдаг арга хандлагын талаарх нэмэлт мэдээллийг [эндээс](#) авна уу.

Бизнес боломжууд

Бизнес боломжууд болон худалдан авалтын талаар үйлчлүүлэгч компанитай холбогдоно уу.

ЕСБХБ-тай хамтран ажиллах боломжууд (худалдан авалттай холбоогүй)-ын талаар сонирхвол дараах утасны дугаар, цахим хаягаар холбоо барина уу.

Утас: +44 20 7338 7168

Цахим шуудан: projectenquiries@ebrd.com

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээлэл авахыг хүсвэл [ЕСБХБ-ны Худалдан авалт](#) хэсэгт зочилно уу.

Утас: +44 20 7338 6794

Цахим шуудан: procurement@ebrd.com

Ерөнхий лавлагаа

Дэлгэрэнгүй лавлагааг [ЕСБХБ-ны Лавлагааны маягт](#) ашиглан авах боломжтой.

Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ)

[БОНБ](#) болон холбогдох Гүйцэтгэлийн Шаардлагууд (ГШ) нь ЕСБХБ-ны “байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил”-ийг хөхиүлэн дэмжих үүрэг амлалтаа биелүүлэхэд баримтлах арга замуудыг тодорхойлдог. БОНБ болон ГШ-д үйлчлүүлэгчийн зүгээс олон нийтийн мэдээлэл, хэлэлцүүлгийн талаарх үндэсний хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг дагаж мөрдөх, мөн оролцогч талуудын санал гомдол, ялангуяа үйлчлүүлэгч ба төслийн байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн талаарх санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг гомдол барагдуулах механизм бий болгох тухай тодорхой заалтууд багтсан байдаг. ЕСБХБ нь аливаа төслийн байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөллийн мөн чанар, цар хүрээнд дүйцүүлэн, тухайн төслийн улмаас үүсэх эрсдэл, үр нөлөөллийн тухай мэдээллийг шаардлагын дагуу ил болгох, эсвэл оролцогч талуудтай утга учиртай зөвлөлдөх, тэдний санал хүсэлтийг харгалзан үзэж, хариу өгөх нэмэлт шаардлагыг үйлчлүүлэгчиддээ тавьдаг.

Энэ чиглэлд ЕСБХБ-ны хэрэгжүүлдэг практикийн талаарх нэмэлт мэдээллийг [БОНБ](#)-д оруулсан болно.

Бүрэн төгс байдал ба комплаенс

ЕСБХБ-ны Комплаенс хариуцсан Захирлын Ажлын алба (КЗАА) нь сайн засаглалыг хөхиүлэн дэмжиж, олон улсын шилдэг практикт нийцүүлэн Банкны бүхий л үйл ажиллагаан дахь бүрэн төгс байдлыг хамгийн дээд стандартаар хангахад анхаарч ажилладаг. Төслүүдийн зүгээс Банкинд бүрэн төгс байдал, нэр хүндийн хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй эрсдэл үүсгэхгүй байх нөхцлийг хангахын тулд тус Банк бүх үйлчлүүлэгчийнхээ бүрэн төгс байдалд нарийвчилсан үнэлгээ хийдэг. Банк аливаа асуудлыг төслийн үнэлгээг батлах үе шатанд илрүүлэн тогтоож, шийдвэрлэх нь Банкны транзакцийн бүрэн төгс байдлыг хангах хамгийн үр дүнтэй арга зам гэж үзэж байна. КЗАА нь эдгээр хамгаалалтын арга хэмжээг авахад голлох үүрэг гүйцэтгэж, мөн төслүүдийн хөрөнгө оруулалтын дараах бүрэн төгс байдлын эрсдлийг хянахад тус дөхөм үзүүлдэг.

Түүнчлэн, КЗАА нь ЕСБХБ-ны санхүүжүүлсэн төслүүдтэй холбоотой залилан мэхлэлт, авилга, хээл хахууль болон буруу үйлдлийн талаарх гомдлын мөрөөр судлан шалгах үүрэгтэй. Банкны ажилтнууд, эсвэл гадна байгаа хэн ч бай залилан мэхлэлт болон авилгал үйлдэгдсэн хэмээн сэжиглэж буй тохиолдолд Комплаенс хариуцсан захиралд compliance@ebrd.com цахим шуудангийн хаяг руу бичгээр

илтгэх ёстой. Мэдээлэгдсэн бүхий л асуудлын мөрөөр хянан шийдвэрлэх ажлыг КЗАА гүйцэтгэнэ. Нэр хаягтай болон нэр хаяггүй бүх мэдээллийг шалгана. Мэдээллийг Банкны албан ёсны хэл болон үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын хэлний алинаар ч үйлдэж болно. Ирүүлсэн мэдээлэл нь чин сэтгэлийн байх ёстой.

Мэдээллийн хүртээмжийн бодлого (МХБ)

МХБ нь 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш ЕСБХБ мэдээллийг хэрхэн олон нийтэд ил тод болгох, өөрийн стратеги, бодлого болон үйл ажиллагааны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэн сурталчлах чиглэлд оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөх арга замуудыг тодорхойлсон байдаг. ЕСБХБ-ны вэб сайтаас ямар мэдээлэл авах боломжтойг мэдье гэвэл [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#) хуудсанд зочилно уу.

Мэдээлэл авах тодорхой хүсэлтээ [ЕСБХБ-ны Лавлагааны маягт](#) ашиглан илгээх боломжтой.

Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)

Хэрэв байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбоотой санал гомдлоо үйлчлүүлэгч болон Банкинд тавьж шийдвэрлүүлэх (жишээлбэл: үйлчлүүлэгчийн Төслийн түвшний гомдол барагдуулах механизмаар дамжуулж, эсвэл Банкны удирдлагатай шууд харилцах замаар) оролдлого, хүчин чармайлт нь амжилтгүй болвол, хувь хүн болон байгууллагууд санал гомдлоо ЕСБХБ-ны Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)-аар дамжуулан шийдвэрлүүлэхийг зорьж болно.

ТХХБМ нь Төсөлтэй холбоотой бусдад хор хохирол учруулсан (эсвэл учруулж болзошгүй) гэж үзэж буй асуудлуудыг хараат бусаар хянан шалгадаг. Энэхүү Механизмын зорилго нь байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбогдох асуудлуудыг шийдвэрлэх талаар Төслийн оролцогч талуудын хоорондох яриа хэлэлцээг дэмжих; Банк өөрийн [Байгаль орчин, нийгмийн бодлого](#), эсвэл [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#)-ын Төсөлд холбогдох заалтуудыг дагаж мөрдсөн эсэхийг тогтоох; мөн шаардлагатай тохиолдолд Банкны зүгээс эдгээр бодлогод үл нийцсэн зөрчлийг арилгах, түүний зэрэгцээ цаашид тийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

ТХХБМ болон түүний эрх үүргийн талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл [Төслийн хариуцлагын хараат бус механизмын вэб сайт](#), хянан шалгуулах хүсэлт тавих бол [Хүсэлт](#) хаягаар тус тус хандана уу. Эсвэл ТХХБМ-ын талаар, мөн санал хүсэлт

хэрхэн тавих тухай чиглэл заавар, нэмэлт мэдээлэл авах бол ipam@ebrd.com цахим шуудангаар хандаж болно.